



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠶᠢᠨ
ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ


2023

11 сар










www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2023 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	13
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2022 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	170 805	37 109	6 214	34 590	55 283	37 609
Үүнээс:						
Тэмээ	54	32	-	20	2	-
Адуу	15 545	4 115	634	3 424	3 804	3 568
Үхэр	16 278	4 162	1 182	3 450	3 843	3 641
Хонь	84 995	17 874	2 270	17 162	29 866	17 823
Ямаа	53 933	10 926	2 128	10 534	17 768	12 577

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний XI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 I-XI	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	2023 I-XI
Суурин хүн ам	тоо	29 663	29 342	29 433	29 341	
Төрөлт	тоо	572	520	522	500	503
Нас баралт	тоо	151	145	166	160	139
Шилжиж ирсэн	тоо	396	935	511	819	736
Цэвэр өсөлт	хувь	1.42'	1.28	1.20	1.16	1.24'

' өмнөх оны суурин хүн амын тооноос тооцов.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2022 ОН






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2023 оны 11 сарын эцэст 126 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 12 (8.7%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН, XI сарын байдлаар




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 115 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 60 (52.1%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, ШАЛТГААНААР, XI сарын байдлаар



Тайлант хугацаанд 23 иргэн ажилд зуулчлуулж орсон байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 31 (24.6%) нь 15-24 насны, 40 (31.7%) нь 25-34 насны залуучууд, 36 (28.6%) нь 35-44 насныхан, 18 (14.3%) нь 45-60 насныхан, 1 буюу 0.6% нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, XI сарын байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйдлийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2022 XI	2023 XI	2022 XI	2023 XI
Ажилгүйдлийн бүгд	138	126	77	72
Үүнээс:				
Дээд боловсролтой	37	42	23	32
Тусгай дунд боловсролтой	9	13	5	1
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	14	8	7	3
Ерөнхий боловсролтой	74	60	41	34
Бага болон боловсролгүй	4	3	1	2

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 42 (33.3%) нь дээд боловсролтой, 13 (10.3%) нь тусгай дунд боловсролтой, 8 (6.3%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 60 (47.6%) нь ерөнхий боловсролтой, бага буюу боловсролгүй иргэн 3 буюу 2.4% байна. Ажил хайгч иргэдийн 72 (57.1%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 46.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 25.5 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр, зарлага 47.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13.5 (40.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 37.0 (80.5%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 1.7 (3.8%) төгрөг тэтгэмжийн сангаас, 2.5 (5.5%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 3.8 (8.2%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 936.6 (2.0%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний XI сард

Үзүүлэлт	2022	2023	Өсөлт бууралт	
	I-XI	I-XI	тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	20 459.5	45 984.3	25 524.8	124.8
тэтгэврийн сан	13 761.9	37 006.0	23 244.1	168.9
тэтгэмжийн сан	1 450.6	1 740.1	289.5	20.
ажилгүйдлийн сан	287.7	936.6	648.9	225.5
ҮОМШӨ ¹ -ний сан	1 643.0	2 508.1	865.1	52.7
ЭМД ² -ын сан	3 316.3	3 793.5	477.2	14.4
Сангийн зарлага, бүгд	33 650.9	47 187.6	13 536.7	40.2
тэтгэврийн сан	30 042.8	36 113.9	6 071.1	20.2
тэтгэмжийн сан	1 155.8	8 120.8	6 965.	7.0*
ҮОМШӨ-ний сан	1 798.4	2 051.0	252.6	14.
Ажилгүйдлийн сан	653.9	901.9	248.0	37.9

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4955 хүнд 36.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 2762 хүнд 8.1 тэрбум төгрөгийн тэтгэмж, 652 хүнд 2.1 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 263 хүнд 901.9 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах талаар тусгасан. Үүний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг бүхэлд нь цахимжуулж дүүрэгт санхүүжилт хуваарилалт хийгдэхгүй Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нэг данснаас зарцуулалт хийгдэж байна.

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний XI сард

Үзүүлэлт	2022		2023		2023.XI	2023.I-XI
	XI	I-XI	XI	I-XI	2022.XI	2022.I-XI
	сая төгрөг				хувь	
Сангийн зарлага	371.3	14 324.2	2 560.5	16 177.6	822.5	113.4
Тэтгэвэр	131.9	1 380.1	145.6	1 484.7	110.4	107.6
Тэтгэмж	34.8	374.4	99.9	708.6	287.1	189.3
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	29.2	321.5	34.5	388.7	118.2	120.9
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	117.8	-	113.7	-	96.5
"Алдарт эх" II одонт эхчүүд	-	166.6	-	171.9	-	103.2
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	8.0	89.0	5.8	77.1	72.5	86.6
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	-	10 339.6	2 136.0	11 662.2	35.6*	112.8
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	54.5	617.3	49.3	571.3	90.5	92.5
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	32.9	193.0	27.8	267.1	84.5	138.4
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	57.5	90.0	34.0	93.8	59.1	104.2
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	14.7	170.8	13.1	147.1	89.1	86.1
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	-	64.6	0.1	101.1	-	156.5
ОНО-д түшиглэсэн халамж	2.2	67.6	7.2	92.2	3.3*	136.4
Ихэр хүүхдийн тэтгэмж	2.0	8.0	2.0	16.0	100.0	200.0
АДЗГ урамшуулал	-	-	2.8	4.4	-	-
Онцгой тохиолдлын тэтгэмж	3.6	12.0	2.4	13.2	66.7	110.0
Насны хишиг	-	251.9	-	264.5	-	105.0

*-дахин их

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 462 хүнд 1.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 378 хүнд 708.6 сая төгрөгийн тэтгэмж, 276 хүнд 388.7 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 163 жирэмсэн эхэд 77.1 сая төгрөгийн тэтгэмж, 10.7 мянган хүүхдэд 11.7 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдэд асардаг 1062 эхэд 571.3 сая төгрөгийн тэтгэмж, 2268 ахмад настанд 267.1 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 1132 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 147.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 438 иргэдэд 93.8 сая төгрөгийн хөнгөлөлт, ихэр хүүхдийн тэтгэмж 8 өрхөд 16.0 сая төгрөг, 36 хүнд амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал 4.4 сая төгрөг, 11 хүнд 13.2 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмж, 1728 хүнд 264.5 сая төгрөгийн насны хишиг, өрх толгойлсон 63 эх, эцэгт 101.1 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.




ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар 522 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 6 (1.1%) буурсан байна. Энэ хугацаанд 189.8 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 13.9 (6.5%) мянган хүнээр буурсан

бол, хэвтэн эмчлүүлсэн 8.5 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 (18.0%) мянган хүнээр өссөн байна.


ЗУРАГ 7. АМБУЛАТОРИЙН ҮЗЛЭГ, эхний XI сард



ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний XI сард

Үзүүлэлт	2022 I-XI	2023 I-XI	<u>2023.I-XI</u> 2022.I-XI
Амаржсан эхийн тоо	527	517	98.1
Үүнээс бусад аймгийн харьяат	146	155	106.2
Амьд төрсөн хүүхэд	528	522	98.9
Үүнээс бусад аймгийн харьяат	141	154	109.2
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	6	6	100.0

ЗУРАГ 8. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



2023 оны эхний 11 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 93 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 20.6%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 50 (35.0%) тохиолдлоор буурсан бол, цочмог халдварт өвчний 359 тохиолдол

бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 79.4%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 298 (4.8 дахин их) тохиолдлоор өссөн байна. Тайлант хугацаанд ковид-19 өвчний 44 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1681 (97.4%) тохиолдлоор буурсан байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 168.8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 492.5 продицмиллээр буурсан байна.

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний XI сард

Үзүүлэлт	2022 I-XI	2023 I-XI	Өсөлт бууралт
Нийт халдварт өвчин	1 929	496	-1 433
Бэлгийн замын халдварт өвчин	143	93	-50
Заг хүйтэн	60	49	-11
Тэмбүү	32	32	-
Мөөгөнцөр /кандидоз/	7	1	-6
Трихомониаз	38	11	-27
Кандилом	3	-	-3
Хомхой	3	-	-3
Цочмог халдварт өвчин	1 786	403	-1 383
Цусан суулга	8	25	17
Гепатит А	2	-	-2
Скарлатин	1	30	29
Салхин цэцэг	39	230	191
Сальмонеллез	-	11	11
Ковид-19	1 725	44	-1 681
Рож	1	9	8
Гар хөл амны өвчин	2	32	30
Сүрьеэ	8	22	14



ГЭМТ ХЭРЭГ


2023 оны эхний 11 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 187 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8 (4.1%) хэргээр буурсан бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 60.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.5 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний XI сард

Хэргийн төрөл	2022 I-XI	2023 I-XI	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	195	187	-8	-4.1	100.0
Хүнийг алах	2	2	-	-	1.1
Хүний амьд явах эрхийн эсрэг	2	2	-	-	1.1
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	5	-	-	2.7
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	87	74	-13	-14.9	39.6


Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг	-	1	1	-	0.5
Бусдын эд хөрөнгө хулгайлах	38	31	-7	-18.4	16.6
Залилан мэхлэх	29	33	4	13.8	17.6
Дээрэмдэх	3	2	-1	-33.3	1.1
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1	-	-1	-100.0	0.0
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	11	7	-4	-36.4	3.7
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	2	4	2	100.0	2.1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	7	11	4	57.1	5.9
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	8	3	-5	-62.5	1.6
Хууль бусаар ан агнах	-	1	1	-	0.5
Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	-	1	1	-	0.5
Хуурамч бичиг баримт үйлдэх, ашиглах	-	3	3	-	1.6
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	3	3	-	1.6
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	1	1	-	0.5
Мал хулгайлах	-	2	2	-	1.1
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх	-	1	1	-	0.5
Хэрэг илрүүлэлтийн хувь	58.5	60.0			

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 74 (39.6%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 33 (17.6%) нь залилан мэхлэх, 31 (16.6%) нь хулгайн хэргүүд эзэлж байна. Тайлантаар хугацаанд тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 11 (5.9%), хөрөнгө завших хэрэг 7 (3.7%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэг 5 (2.7%), бусдын эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг 4 (2.1%), хууль сахиулагчийг эсэргүүцэх, хуурамч бичиг баримт үйлдэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг тус бүр 3 (4.8%), хүнийг алах, амьд явах эрхийн эсрэг хэрэг, дээрэмдэх, мал хулгайлах хэргүүд тус бүр 2 (4.4%), гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, хууль бусаар ан агнах, мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх хэргүүд тус бүр 1 (2.7%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, эхний XI сард

Хэргийн төрөл	2022 I-XI	2023 I-XI	Дүнд эзлэх хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	195	187	100.0
Гэр, орон сууцанд	84	64	34.2
Гудамж талбайд	30	23	12.3
Олон нийтийн газарт	13	31	16.6
Аж ахуйн нэгж, байгууллагад	20	28	15.0
Автозамд	6	11	5.9
Бусад	42	30	16.0

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг төрлөөр нь авч үзэхэд 64 (34.2%) нь гэр, орон сууцанд, 23 (12.3%) гудамж талбайд, 31 (16.6%) нь олон нийтийн газарт, 28 (15.0%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 11 (5.9%) нь автозамд, үлдсэн хэсэг нь буюу 30 нь (16.0%) бусад газарт тус тус үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний XI сард



ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний XI сард




ХҮСНЭГТ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний XI сард

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2022 I-XI	2023 I-XI	тоо	Хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	139	127	-12	-8.6
Үүнээс: эмэгтэйчүүд	17	14	-3	-17.6
хүүхэд	4	6	2	50.0
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	197	177	-20	-10.2
Үүнээс: нас барсан	6	5	-1	-16.7
гэмтсэн	92	86	-6	-6.5
Эрүүлжигдсэн хүний тоо	587	361	-226	-38.5
Баривчлагдсан хүний тоо	187	182	-5	-2.7
Учирсан хохирол /сая төгрөг/	325.3	454.2	128.9	39.6
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	190.2	254.7	64.5	33.9

*-дахин их

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, эхний XI сард



2023 оны эхний 11 сард 127 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 14 (11.0%) нь эмэгтэйчүүд, 6 (4.7) нь 18 хүртлэх насны хүүхэд байна. Тайлант хугацаанд 177 иргэн гэмт хэргийн улмаас хохирсон ба 5 иргэний амь нас хохирч, 86 иргэн гэмтсэн байна. Мөн 361 иргэн эрүүлжигдэж, 182 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн иргэд 226 (38.5%)-аар, баривчлагдсан иргэд 5 (2.7%) иргэнээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 454.2 сая төгрөгийн хохирол учирсны 254.7 (56.1%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




ҮНЭ ХАНШ

2023 оны 11 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ХҮСНЭГТ 11. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, XI сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжээ нэгж	11.03	11.10	11.17	11.24
"Алтан тариа" гурил	Дээд	кг	3 100	3 100	3 100	3 100
	I зэрэг	кг	2 650	2 650	2 650	2 650
	II зэрэг	кг	2 000	2 000	2 000	2 000
Будаа	цагаан	кг	3 800	3 800	3 800	3 800
	шар	кг	3 000	2 900	2 900	2 900
Хонины мах	ястай	кг	9 800	9 000	9 000	9 000
	цул	кг	13 500	13 500	13 500	13 500
Үхрийн мах	ястай	кг	13 500	13 500	13 500	13 500
	цул	кг	15 500	15 500	15 500	15 500
Адууны мах, ястай		кг	9 500	9 500	9 500	9 500
Ямааны мах		кг	7 500	7 000	7 000	7 000
Элсэн чихэр		кг	4 500	4 800	4 800	4 800
Сүү /задгай/		л	2 500	3 000	3 500	3 500
Тараг /задгай/		л	3 000	4 000	4 000	4 000
Цэцгийн тос, Орос		кг	6 050	6 050	6 050	6 050
Байцаа		кг	1 000	1 000	1 000	1 000
Манжин		кг	1 300	1 500	1 500	1 500
Төмс	монгол	кг	1 200	1 200	1 200	1 200
Лууван	монгол	кг	1 400	1 500	1 500	1 500
Сонгино	хятад	кг	2 400	2 500	2 500	2 500
	монгол	кг	2 600	2 500	2 500	2 500
Сармис, булцуу		ш	830	830	830	830
Огурцы, хятад		кг	5 500	5 500	5 500	5 500
Помидор, хятад /үрлэн/		кг	6 500	6 000	6 000	6 000
Ургамлын тос/ siesta/		ш	12 800	12 800	12 800	12 800
Өндөг		ш	650	590	580	600
Атар талх		ш	2 500	2 500	2 500	2 500

ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XI сард



ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XI сард



ХҮСНЭГТ 12. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	110.5
• Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	130.3
2 тарифт тоолууртай		
• Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	116.4
• Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	89.2
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг	төг/квт.ц	164.0

• Сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас их хэрэглээг	төг/квт.ц	187.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	164.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	256.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	105.0
3 тарифт тоолууртай /сарын нийт хэрэглээний 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг		
• Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	187.0
• Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	291.0
• Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	121.0

* 2019 оны 3 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй айл өрхөд борлуулах тариф

*2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдөж буй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад борлуулах тариф

ХҮСНЭГТ 13. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	845	1м ³	1487
Дулааны суурь тариф	40м ² хүртэл	4 224		
	41м ² - 80м ²	7 040	-	-
	81м ² -аас дээш	14 080		
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	1 гкал	84 272
		1м ³ (тоолууртай)		
	Зун	1 хүн (тоолуургүй)		
		1м ³ (тоолууртай)		
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус түгээх байраар	2.72		
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
	1 л (тоолууртай)	1.5		
	Ус соруулах	15.0		

* 2023 оны 7 сарын 20-ны өдрөөс мөрдөж буй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад цэвэр, бохир усны борлуулах тариф

* 2023 оны 9 сарын 15-ны өдрөөс мөрдөж буй дулаан эрчим хүчний тариф

ХҮСНЭГТ 14. МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

	2019 XI	2020 XI	2021 XI	2022 XI	2023 XI
	төгрөг				
Адууны шир	9 000	6 500	6 000	7 000	-
Үхрийн шир /2.3 метрээс доош/	3 500	3 000	3 000	2 000	-
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	10 000	6 500	7 000	2 000	-
Хонины арьс	2 000	1 500	2 000	-	2 000

ХҮСНЭГТ 15. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2019 XI	2020 XI	2021 XI	2022 XI	2023 XI
	төгрөг				
АИ -76,80	1 810	1 450	2 040	2 400	2 420
АИ -92	1 860	1 470	2 070	2 440	2 440
Дизель түлш	2 390	2 180	2 550	3 590	3 590

2023 оны 11 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин болон дизель түлш өмнөх онтой ижил түвшинд, АИ-80 бензин 20 (0.8%) төгрөгөөр өссөн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2023 оны эхний 11 сард 189.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 49.6 (35.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, эхний XI сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2022 I-XI	2023 I-XI	$\frac{2023.I-XI}{2022.I-XI}$	2022 I-XI	2023 I-XI	$\frac{2023.I-XI}{2022.I-XI}$
Бүгд					139 454.0	189 096.9	135.6
Нүүрс олборлолт	м.тн	3 928.7	4 167.5	106.1	133 157.3	180 494.4	135.5
Дулаан дамжуулалт	м.гкал	144.2	150.1	104.1	4 922.5	6 671.2	135.5
Талх, нарийн боов	тн	233.5	218.7	93.7	744.3	898.9	120.8
Зайлуулсан хог хаягдал	м.м3	46.0	52.9	115	629.9	1 032.4	163.9


ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар




Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 238.8 (6.1%) мянган тонноор буюу 47.3 (38.5%) тэрбум төгрөгөөр, дулаан үйлдвэрлэлт 5.9 (4.1%) мянган гкал-аар буюу 1.7 (35.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Мөн талх, нарийн боовны үйлдвэрлэлт өнгөрсөн оноос биет хэмжээгээр 14.8 (6.3%) тонноор буурч, үнийн дүнгээр 154.6 (20.8%) сая төгрөгөөр

нэмэгдсэн бол зайлуулсан хог хаягдлын хэмжээ 52.9 мянган метр куб болсон нь өмнөх оны мөн үеэс 6.9 (15.0%) мянган метр куб-ээр өссөн үзүүлэлт юм.

ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөг, сараар



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, мянган тонн, жил бүрийн эхний 11 сард



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 2706.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 62.5 (2.3%) сая төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 1139.2 (42.1%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний XI сард

Үзүүлэлт	2022 I-XI	2023 I-XI	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	2 769.3	2 706.8	-62.5
Орон сууц	763.6	519.6	-244.0
Ус борлуулалт, бүгд	1 136.6	1 071.6	-65.0
Хүн амд	519.8	537.7	17.9

Аж ахуйн нэгжид	616.7	533.9	-82.8
Сувагжуулалт	777.0	997.7	220.7
Бусад	92.1	117.9	25.8

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний XI сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	633 591.2	560 359.6	88.4
Тавлаг өргөө	113 844.5	112 438.1	98.8
Маргад өргөө	115 814.5	102 341.8	88.4
Сод хөгжил	130 721.8	127 292.1	97.4
Шинэ элч	120 971.4	108 798.7	89.9
Уурхайчин	75 900.0	62 700.0	82.6
Содон суварга	76 339.0	46 788.9	61.3

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2023 оны 12 дугаар сарын 15

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ 

Валютын ханш 



©2017


аппликейшнаас

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn